



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 1123


Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай" 9/36 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/48 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/48 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх хот тохижилт, нийтийн аж ахуй, барилгын засвар, шинэчлэлтийн ажлын 72, 73, 88, 90, 91, 92 дугаар ажил, 2 дугаар хавсралтаар батлагдсан авто зам, замын байгууламжийн засварын ажлын жагсаалтын 20 дугаар ажил, 3 дугаар хавсралтаар батлагдсан худалдан авах зарим техник, тоног төхөөрөмжийн жагсаалтын 19 дүгээр ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажиллахыг Үнэлгээний хороо /Э.Энхцэцэг/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



• 1110300201

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны 01 сарын 08 өдрийн
А.Эрдэнэболд тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|----------------------|--------------|---|
| Дарга | Э.Энхцэцэг | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга |
| Гишүүд | Б.Түмэнбаяр | Нийслэлийн Мэдээлэл, технологийн газрын, мэдээллийн сүлжээ, техник, хяналтын хэлтсийн дарга |
| | Э.Батжаргал | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн |
| | Р.Дуламжав | Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо 74В-46 тоотод оршин суугч /иргэн/ |
| Нарийн бичгийн дарга | С.Эрдэнэболд | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн |